



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 461

Улаанбаатар хот

**УЛСЫН НӨӨЦӨӨС БАРАА, МАТЕРИАЛ ГАРГАХ, НӨХӨН БҮРДҮҮЛЭХ ТУХАЙ**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.1, Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн зарим аймгуудад улсын нөөцөөс 50 хувь хямдруулан олгох өвс, тэжээлийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.
2. Улсын нөөцөөс 50 хувь хямдруулан олгох өвс, тэжээлийн үнийн зөрүү болон тээврийн зардалд шаардагдах 3,908,604,835 (гурван тэрбум есөн зуун найман сая зургаан зуун дөрвөн мянга найман зуун гучин тав) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.
3. Улсын нөөцөөс олгох өвс, тэжээлийг өвөлжилт хүндэрч байгаа сумдын малчдад оновчтой хуваарилж олгох, зориулалт бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2023 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Улсын нөөцөөс олгосон өвс, тэжээлийг 2023 оны I улиралд багтаан тэжээлээр буцаан нөхөн бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд С.АМАРСАЙХАН

Сангийн сайд Б.ЖАВХЛАН